



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ  
Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 28-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.03.14 № 06

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т тус тус заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд төрийн өмчийн банк болох "Төрийн банк" ХХК-ийн 2012-2022 оны хугацааны үйл ажиллагаатай холбоотой дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Төрийн банкны зээлийн бодлого, нөхцөлийн талаар;
2. Төрийн банкны санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, актив, пассив, тэдгээрийн дэлгэрэнгүй задаргаа;
3. Нийт зээлийг нийт активтай харьцуулсан харьцаа улирал тус бүрээр, Монголбанкнаас тогтоосон хязгаарлалттай харьцуулсан байдлаар;
4. Төрийн банкны активын өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөжийн талаарх тооцооллыг тус банктай дүйцэхүйц хэмжээний дэд бүтэцтэй арилжааны банктай харьцуулсан байдлаар;
5. Малчны, тэтгэврийн, хэрэглээний зээлээс бусад зээлийн хэмжээ, нөхцөл, чанарын үзүүлэлт, барьцаалсан эд хөрөнгө, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг зээлдэгч тус бүрээр;
6. Шүүхээр шийдвэрлүүлэхээр хандсан зээлийн мэдээллийг зээлдэгч тус бүрээр;
7. Эрсдэлийн санг ашигласан зээлийн мэдээллийг зээлдэгч тус бүрээр;
8. 2017 онд "Шинжиан шинфа" ХХК-д олгосон 20 тэрбум төгрөгийн зээлийг олгохыг чиглэл болгосон болон хэрэгжүүлсэн албан тушаалтан, шийдвэрийн үндэслэл, зээлийн нөхцөл, барьцаа хөрөнгө, эргэн төлөлтийн талаар;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Т.АЮУРСАЙХАН

2022000007